



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ №03

НЭГ. Шувууны томуугийн А хүрээний вирусн шувууны өвчлөлийн хураангуй мэдээлэл:

2021 оны 1 дүгээр сарын 18 наас 2 дугаар сарын 01 ний хүртэлх хугацаанд шувууны томуугийн А хүрээний вирус Чех, Япон, Дани, Кувейт, Иран, Герман зэрэг улс орны шувууны аж ахуйд илэрсэн.

ХОЁР. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 1 дүгээр сарын 18 наас 2 дугаар сарын 01 ний хүртэлх хугацаанд шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.

ГУРАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

Мөн хугацаанд шувууны томуугийн А хүрээний H5N6 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн тохиолдол шинээр бүртгэгдээгүй.

ДӨРӨВ. Шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 1 дүгээр сарын 18 наас 2 дугаар сарын 01 ний хүртэлх хугацаанд шувууны томуугийн А хүрээний H7N9 вирусн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

ТАВ. Шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 1 дүгээр сарын 18 наас 2 дугаар сарын 01 ний хүртэлх хугацаанд шувууны томуугийн А хүрээний H9N2 вирусн хүний өвчлөлийн шинэ 1 тохиолдол бүртгэгдсэн. БНХАУ-ын Фужянь мужийн Сямэнь хотын 52 настай эмэгтэй 2021 оны 1 дүгээр сарын 02 нд өвчний шинж тэмдэг илэрч эмнэлэгт хандсан. Өвчний шинж тэмдэг хүндрээгүй бөгөөд өвчтөн бүрэн эдгэрсэн. Өвчтөн шувууны аж ахуйд ойр амьдарч байсан түүх байхгүй. 2020 онд энэхүү хэвшинжийн вирусээр халдвар авсан 16 дахь тохиолдол болж байгаа ба бүгд БНХАУ-д бүртгэгдээд байна.

ЗУРГАА. Шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 1 дүгээр сарын 18 наас 2 дугаар сарын 01 ний хүртэлх хугацаанд шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.


ДОЛОО. 2020 оны 10 дугаар сарын 26 наас 11 дүгээр сарын 9 ний хүртэлх хугацаанд шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн шувууны мэдээлэл:

(Хүснэгт 1) Шувууны томуугийн А хүрээний вирусн тархалт болон вирусн хэлбэр

№	Мэдээлсэн өдөр	Шувууд өвчилж эхэлсэн өдөр	Дэд хэвшинж	Улс	Муж	Өртсөн нийт шувуудын тоо	Өртсөн шувуудын зүйл
1	25/01/2021	22/01/2021	H5N8	Чех	Чешский край	32	Тэжээвэр нугас, галуу
2	26/01/2021	16/11/2020	H5N8	Дани	Виборг	9415	Тэжээвэр Гургуул, галуу
3	21/01/2021	16/11/2020	H5N8	Кувейт	Джахра	112	Тахиа
4	26/01/2021	16/11/2020	H5N8	Иран	Южный Хорасан	84470	Тахиа
5	3/1/2021	16/11/2020	H5N8	Иран	Южный Хорасан	27000	Тахиа
6	26/01/2021	22/01/2021	H5N8	Герман	Бранденбург	8057	Тахиа
7	26/01/2021	22/01/2021	H5N8	Герман	Клоппенбург	71904	Цацагт хяруул
8	28/01/2021	22/01/2021	H5N8	Герман	Мекленбург-Померан	7350	Тахиа
9	28/01/2021	22/01/2021	H5N8	Япон	Чиба-Кэн	1150000	Тахиа
10	28/01/2021	22/01/2021	H5N8	Япон	Кагосима	34000	Тахиа

Эх сурвалж: *Oie.int, Cidrap.umn.edu*

(Зураг 1) Шувууны томуугийн А хүрээний вирус тархалт /зургаар/



ДОЛОО. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдолын мэдээлэл:

2021 оны 1 дүгээр сарын 18 наас 2 дугаар сарын 01 ний хооронд шувууны томуугийн өвчлөлийн сэжигтэй, үхсэн тохиолдол бүртгэгдээгүй байна.

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Шувууны томуу хариуцсан баг